

**“МОНОС ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04 дүгээр
сарын 29-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь заалтыг удирдлага болгон “Монос хүнс” ХК-ийн 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг 2023 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн, хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг тоолсон Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. “Монос хүнс” ХК-ийн 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг энэхүү тогтоолын хавсралт №01-ээр баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Х.АНАНД



2023 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн
ХЭЭХ-ийн01... тоот тогтоолын Хавсралт №01

Монос Хүнс ХК-ийн 2022 оны санхүү, үйл ажиллагааны тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлт

Монос Хүнс ХК-ийн 2022 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд өгөх дүгнэлт, 2022 оны зорилтуудын биелэлтийн талаарх илтгэлийг Компанийн тухай хууль, Монос Хүнс ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна.

Монос Хүнс ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2022 оны 4 дүгээр сард шинэчлэгдэн сонгогдсон бөгөөд өнгөрсөн хугацаанд компанийг удирдах үйл ажиллагаандаа сайн засаглалын зарчмууд, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдлөг болгон ажиллаа. Компанийн Гүйцэтгэх удирдлагын баг нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэр, зөвлөмж, төлөвлөгөөт зорилтуудыг амжилттай хэрэгжүүлсээр ирсэн байна.

Монос Хүнс ХК-ийн 2022 оны гол зорилт нь

- Эрүүл мэндийн хүнсний үйлдвэрлэлийг жигд тасралтгүй явуулах
- Борлуулалтын хэмжээг 2021 оноос 44%-аар нэмэгдүүлж 26.4 тэрбум төгрөгт хүргэх,
- Цэвэр ашгийн хэмжээг 2021 оноос 40%-аар нэмэгдүүлж 2.8 тэрбум төгрөгт хүргэх,
- Цар тахлын дараах эдийн засгийн сэргэлтийн үед санхүүгийн үзүүлэлтүүдээ сайжруулахад чиглэсэн юм.

Компани 2022 онд зах зээлд 2 нэр төрлийн бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүлж нийт 76 нэр төрлийн бүтээгдэхүүнтэйгээр үйлдвэрлэлээ үргэлжлүүлэн 106%-ийн биелэлттэй буюу 28 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой, 3.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай буюу төлөвлөгөөний биелэлт 107%-ийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Хил гаалийн тодорхойгүй байдал, тээвэр ложистик болон түүхий эдийн үнийн өсөлт, гадаад валютын ханшийн өөрчлөлт өндөр байсан хэдий ч стратегийн оновчтой шийдвэр гаргалтуудын үр дүнд тавьсан зорилтоо давуулан биелүүлсэн байна. Гүйцэтгэх удирдлагын багт ТУЗ-өөс өгсөн чиглэлийн дагуу үйлдвэрийн өргөтгөлийн MFC 2.0 төсөл амжилттайгаар эхэлж бүтээн байгуулалтын ажлууд ид өрнөж байна.

Монос Хүнс ХК нь цаашдын ажлын төлөвлөгөө, үйл ажиллагаандаа дараах чиглэлийг тусган хэрэгжүүлэх нь зүйтэй гэж Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс үзэж байна. Үүнд:

- MFC 2.0 төслийн ажлыг төлөвлөсөн хугацаандаа дуусгаж ашиглалтад оруулах
- Тээвэрийн үнийн өсөлт, түүхий эдийн тасалдалд дүн шинжилгээ хийж ашигт ажиллагааг хангаж ажиллах
- Хувьцааны ханшийн өсөлтийг тогтвортой байлгах

Монос хүнс ХК-ийн Гүйцэтгэх удирдлагын багийн хамт олон 2022 онд төлөвлөсөн зорилтоо давуулан биелүүлж 2021 онтой харьцуулахад борлуулалтын орлогоо 50%, цэвэр ашгаа 57%-аар өсгөж ажилласан тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зүгээс “онц сайн” ажилласан хэмээн дүгнэж байна.

Монос Хүнс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл

**“МОНОС ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04 дүгээр
сарын 29-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар
хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2023 оны төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь заалтыг удирдлага болгон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооноос гаргасан саналыг 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлж, хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн цалин, урамшууллын хэмжээг болон хурлын үйл ажиллагаанд шаардагдах 2023 оны төсвийг энэхүү тогтоолын Хавсралт №01-д заасны дагуу баталсугай.
2. Энэхүү тогтоолоор батлагдсан төсөвт хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх болон цалин урамшуулал хорооны дарга/Б.Гантулга/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Х.АНАНД



2023 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн
ХЭЭХ-ын тоот тогтоолын хавсралт №01

МОНОС ХҮНС ХК ТУЗ-ИЙН 2023 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

	/мянган төгрөг/
1. ТУЗ-ийн хурлын зардал	8,000
• ТУЗ-ийн ээлжит хурал	4,000
• ТУЗ-ийн ээлжит бус хурал	4,000
2. ТУЗ-ийн гишүүдийн цалин, НДШ	71,289
• ТУЗ-ийн ээлжит хурал	59,289
• ТУЗ-ийн ээлжит бус хурал	12,000
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зардал	30,000
НИЙТ ДҮН	109,289

“МОНОС ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 дүгээр
сарын 29-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар
хот

“Монос хүнс” ХК-ийн дүрэмд
нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь заалт, 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлж, хурлын Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монос хүнс” ХК-ийн дүрэмд дараах нэмэлт өөрчлөлтийг оруулж, нэмэлт өөрчлөлт оруулсан дүрмийг энэ тогтоолын хавсралт №01-ээр баталсугай.
 - 1.1. Дүрмийн 6-р зүйлийн 6.3 дахь хэсгийг **“6.3. ТУЗ нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг дагаж мөрдүүлнэ. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг дараах байдлаар зохион байгуулж болно. Үүнд:**
 - 6.3.1. танхимаар буюу хувьцаа эзэмшигч биечлэн оролцох
 - 6.3.2. зайнаас буюу мэдээллийн технологийн шийдэл ашиглан цахим хэлбэрээр оролцох
 - 6.3.3. хосолсон /танхимаар болон зайнаас / гэж өөрчлөх;
 - 1.2. Дүрмийн 6-р зүйлийн 6.16 дахь хэсгийг **“6.16. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудлыг цахим хэлбэрээр, эчнээ санал хураах замаар шийдвэрлэж болно. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулж болохгүй. Хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах тохиолдолд энэ дүрмийн 6.3-д заасан журмын 4 дүгээр бүлэгт зааснаар зохион байгуулна”** гэж өөрчлөх;
 - 1.3. Дүрмийн 6-р зүйлийн 6.17 дахь хэсгийг **“6.17. Цахим хэлбэрээр болон эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд энэхүү шийдвэрт компанийн тухай хуулийн 73.3-т заасан асуудлыг тусгасан байна”** гэж өөрчлөх;
 - 1.4. Дүрмийн 6-р зүйлийн 6.18 дахь хэсгийг **“6.18. Цахим хэлбэрээр болон эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлыг тусгасан санал хураах хуудас, цахим санал хураалтыг хүлээн авах сүүлчийн өдрөөс ажлын 30-аас доошгүй хоногийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэдэг аргаар хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх бөгөөд саналын хуудсыг хүлээн авах, цахим санал хураалтыг хянах, шалгах, санал тоолох ажлыг Тооллогын комисс хариуцан гүйцэтгэнэ”** гэж өөрчлөх;
 - 1.5. Дүрмийн 7-р зүйлийн 7.2 дахь хэсгийг **“7.2. Компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байна. ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 3 (гурав) жилийн**

хугацаатай сонгох ба ТУЗ-ийн гишүүний эрх дараагийн ТУЗ-ийн гишүүд сонгогдсоноор дуусгавар болно. ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгож болох бөгөөд хувьцаа эзэмшигч биш этгээд ТУЗ-ийн гишүүнээр сонгож ажиллуулж болно. ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэг нь хараат бус гишүүдээс бүрдэнэ” гэж өөрчлөх;

- 1.6. Дүрмийн 8-р зүйлийн 8.11.7 дахь хэсгийг “8.11.7. Компанийн албадыг нэгдсэн удирдлагаар хангах, компанийн бүтэц зохион байгуулалтын нэгжийг байгуулан ажиллуулах, гүйцэтгэх удирдлагыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх удирдлагын багийн гишүүдийг томилох, чөлөөлөх” гэж өөрчлөх;
- 1.7. Дүрмийн 9-р зүйлийн 9.1 дэх хэсэгт “9.1. ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал, Үйл ажиллагаа хариуцсан захирал, Санхүү хариуцсан захирал, Ерөнхий нягтлан бодогч, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэр гаргахад оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно” гэж нэмэлт оруулах;
2. Компанийн дүрэмд дээрх нэмэлт өөрчлөлт оруулсан заалтаас бусад зүйл заалтад өөрчлөлт оруулаагүй хэвээр мөрдөгдөнө.
3. Нэмэлт өөрчлөлт оруулсан дүрмийг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /А.Отгондарь/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН
ХУРЛЫН ДАРГА



 Х.АНАНД



2023 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн
СЭХ-ын 03 тоот тогтоолоор батлав

“МОНОС ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монос Хүнс компани нь /цаашид “Компани” гэх/ Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан холбогдох журам болон бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах нээлттэй хувьцаат компани /цаашид “ХК” гэх/ байна.
- 1.2. Компанийн оноосон нэрийг монгол хэлээр “Монос хүнс” Хувьцаат компани /ХК/, англи хэлээр “Monos foods” Joint Stock Company /JSC/ гэж нэрлэнэ.
- 1.3. Компани нь Монгол улсын хуулийн дагуу эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн аж ахуйн нэр, барааны тэмдэг болон бэлэгдэл, албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тамга, тэмдэг хэрэглэнэ.
- 1.4. Компанийн албан ёсны хаяг:
Монос хүнс ХК
Чингисийн өргөн чөлөө 205/2
2 дугаар хороо, Хан-Уул дүүрэг
Улаанбаатар -17043-0017, Монгол улс
Харилцах утас: (+976) 7777-3525
Цахим шуудан: foods@monos.mn
Цахим хаяг: www.monosfoods.mn

Хоёр. Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэл

- 2.1. Компани нь Иргэний хууль, Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зөвшөөрсөн дараах ажил үйлчилгээг эрхэлнэ. Үүнд:
 - 2.1.1. Жүүс, ундаа, чихэр, үрэл, цай, зөөлөн капсултай бүтээгдхүүн үйлдвэрлэл
 - 2.1.2. Гадаад худалдаа
- 2.2. Компани нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.
- 2.3. Компани нь тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагааг холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авснаар эрхлэх бөгөөд тухайн зөвшөөрлийн нөхцөл, хугацааг чанд мөрдөж ажиллана.
- 2.4. Компани нь өөрийн зорилго болон эрхлэх үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхтэй шууд буюу шууд бус холбоотой, хууль тогтоомжоор хориглоогүй бүхий л төрлийн үйл ажиллагаа эрхлэх болон ажил гүйлгээг хийх бүрэн эрхтэй байна.
- 2.5. Компани нь охин болон хараат компани, салбар төлөөлөгчийн газар байгуулж болно. Салбар төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй ба Компаниас баталсан дотоод журмын дагуу үйл ажиллагаа явуулна.
- 2.6. Компани нь өөрийн бизнес үйл ажиллагаатай холбоотой зүйлийг хуулийн дагуу нууцалж болно.

Гурав. Компанийн өөрийн хөрөнгө, хувьцаа бусад үнэт цаас, түүнийг гаргах, худалдах, эргүүлэн авах

- 3.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаанд хуваагдах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн давуу эрхийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө гэнэ.

- 3.2. Компани нэг бүр нь 5,67 (таван төгрөг жаран долоон мөнгө) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 408,850,428 (дөрвөн зуун найман сая найман зуун тавин мянга дөрвөн зуун хорин найм) ширхэг энгийн хувьцаа бүхий нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2,318,181,926.76 (хоёр тэрбум гурван зуун арван найман сая нэг зуун наян нэгэн мянга есөн зуун хорин зургаан төгрөг далан зургаан мөнгө) байна.
- 3.3. Компанийн энгийн хувьцаа нэг бүр нь нэг саналын эрхтэй байна.
- 3.4. Компанийн хувьцаа эзэмшигч нь дүрмийн санд оруулсан хувь хөрөнгийнхөө хэмжээгээр санхүүгийн хариуцлага хүлээж, алдагдлыг нөхнө.
- 3.5. Хувьцаа эзэмшигчдийн хувьцааны бүртгэлийг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлж, бүртгэлийг хөтлүүлнэ.
- 3.6. Компани нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг дараах байдлаар нэмэгдүүлж, хорогдуулж болно:
 - 3.6.1 Нэгж хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх;
 - 3.6.2 Хувьцаа нэмж гаргах болон худалдан авсан халаасны хувьцааг хүчингүй болгох;
 - 3.6.3 Өөрийн хуримтлагдсан ашгийн хэмжээгээр хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх.
- 3.7. Компани нь энгийн хувьцаанаас гадна өрийн бичиг, хувьцаанд хамаарах бусад үнэт цаас гаргаж болно.
- 3.8. Үнэт цаас гаргах тухай шийдвэрт үнэт цаас гаргах болсон үндэслэл, шалтгаан, гаргах үнэт цаасны төрөл, тоо нэрлэсэн үнэ, үнийн дүн, гаргах хугацаа нөхцөл зэргийг заасан байна.
- 3.9. Компанийн үйл ажиллагааг өргөтгөх, шинэ бизнес эрхлэх, нэмэгдэл хөрөнгийн эх үүсвэр бий болгох зорилгоор компанийн зарласан хувьцааны төрөл болон хэмжээнд багтаан хувьцаа гаргах, гүйлгээнд оруулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.
- 3.10. Хувьцаа бусад үнэт цаасны нийт үнийг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ тогтооно.
- 3.11. Компаниас шинээр гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийг бэлэн мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө болон оюуны өмчийг үнэлэх хэлбэрээр хийж болно. Үнэт цаасны төлбөрт тооцох мөнгөн бус хөрөнгийн үнэлгээг уг хэлбэрээр хийхийг ТУЗ-ийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ. Үнэлгээг тогтоохдоо мэргэжлийн үнэлгээний байгууллагын санал дүгнэлтийг үндэслэл болгоно.
- 3.12. ТУЗ-ийн шийдвэрээр компани нь өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчтэй нь тохиролцсоны үндсэн дээр эргүүлэн худалдаж авч болно. Компани нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг худалдан авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджаас 25 хувиас илүүгүй байна. Худалдан авсан өөрийн хувьцааг халаасны хувьцаа гэнэ.
- 3.13. Компани нь дараах нөхцөлд өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн худалдаж авах шийдвэр гаргаж болно.
 - 3.13.1 Хуульд заасан үүргийнхээ дагуу эргүүлэн авах энгийн хувьцаа бол;
 - 3.13.2 Үнэт цаасаа эргүүлэн авсны дараа төлбөрийн чадвартай байвал;
 - 3.13.3 Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь компанийн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан доод хэмжээ болон гаргасан давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их бол
- 3.14. Компанийн хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшиж байгаа хувьцаагаа чөлөөтэй захиран зарцуулах эрх эдэлнэ.
- 3.15. Компанийн хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан худалдахаас бусад хэлбэрээр шилжүүлсэн бол хувьцаа эзэмшигчийн бүртгэл

хөтлөх этгээд буюу үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй.

Дөрөв. Компанийн үндсэн эрх, үүрэг, хариуцлага

- 4.1. Компани нь хууль болон энэ дүрэмд заасны хүрээнд үйл ажиллагаагаа явуулахдаа ажил мэргэжлийн туршлагатай, ур чадвартай хүмүүсийг Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн гэрээгээр авч ажиллуулах ба ажиллах нөхцөл, цалин урамшуулал зэргийг дотоод журам эрх зүйн баримт бичгээр тогтооно.
- 4.2. Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.
- 4.3. Компани нь өөрийн хувьцаа эзэмшигчдийн хариуцлагыг хүлээхгүй бөгөөд хувьцаа эзэмшигчид нь компанийн хариуцлагыг өөрийн эзэмшлийн хувьцааны хэмжээгээр хүлээнэ.
- 4.4. Компанийн эрх бүхий албан тушаалтан өөрийн хууль бус үйл ажиллагаанаас шалтгаалж компанид учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцна.
- 4.5. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

Тав. Хувьцаа эзэмшигчийн эрх үүрэг, хариуцлага

- 5.1. Компанийн энгийн хувьцааг зохих журмын дагуу худалдан авч эзэмшсэн иргэн, хуулийн этгээд компанийн хувьцаа эзэмшигч болно.
- 5.2. Компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин суугаа хаяг болон өөрийн эзэмшилдээ байгаа үнэт цаасны тоо, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар бүртгэл хөтлөх этгээдэд зохих журмын дагуу мэдэгдэх үүрэг хүлээнэ.
- 5.3. Хувьцаа эзэмшигч нь компанийн нэрийг хувийн ашиг сонирхолд ашиглах, компанийн ажил хэргийн нэр хүнд, өмч хөрөнгөнд гэм хор учруулж болзошгүй үйлдэл хийхийг хориглоно.
- 5.4. Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ.
 - 5.4.1 Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хэлэлцэж буй асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх;
 - 5.4.2 ТУЗ-ийн хурлаас ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед эзэмшиж буй хувьцаанд оногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хууль журамд заасан хугацаандаа олгохгүй бол алданги төлөхийг шаардах;
 - 5.4.3 Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1-д заасны дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогыг компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүүлэн хуваарилна;
 - 5.4.4 Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан журмын дагуу тэргүүн ээлжинд худалдан авах;
 - 5.4.5 Дор дурдсан асуудлаар гаргасан хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр өөрийн эзэмшиж байгаа хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрхтэй. Үүнд:
 - 5.4.5.1 Нийлэх, нэгдэх, хуваах болон компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулах бол;
 - 5.4.5.2 Хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргасан зэргээр их хэмжээний хэлцэл хийсэн бол;

- 5.4.5.3 Компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан бол;
- 5.4.5.4 Нэг хувьцаа эзэмшигч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигчид компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
- 5.4.6. Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувьцаа эзэмшиж буй этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар ТУЗ-д санал хүргүүлэх, ТУЗ энэ саналыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрөө зарлан хуралдуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал зарлагдсан үед хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг шаардан гаргуулах;
- 5.4.7. Хууль тогтоомж болон энэхүү дүрмээр тогтоосон бусад эрх.

Зургаа. Хувьцаа эзэмшигчдийн хурал

- 6.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид “ХЭХ” гэх) байна.
- 6.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус байна.
- 6.3. ТУЗ нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг дагаж мөрдүүлнэ. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг дараах байдлаар зохион байгуулж болно. Үүнд:
- 6.3.1. танхимаар буюу хувьцаа эзэмшигч биечлэн оролцох
- 6.3.2. зайнаас буюу мэдээллийн технологийн шийдэл ашиглан цахим хэлбэрээр оролцох
- 6.3.3. хосолсон /танхимаар болон зайнаас /
- /Энэ хэсгийг 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 03 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*
- 6.4. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг Компанийн санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор ТУЗ-өөс зарлаж хуралдуулах бөгөөд Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу шийдвэр гаргаж хуралдуулна.
- 6.5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу ТУЗ-өөс шийдвэрлэж хуралдуулна.
- 6.6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар энэ дүрэмд өөрөөр заагаагүй бол Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт заасан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 6.7. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг ТУЗ-ийн дарга удирдан явуулна. ТУЗ-ийн дарга хуралд оролцох боломжгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай асуудлыг шийдвэрлэсэн ТУЗ-ийн хурлаас томилогдсон этгээд хурлыг удирдана. Хурал удирдахаар томилогдсон этгээд хуралд хүрэлцэн ирэх боломжгүй нь хурал хуралдах үед илэрхий болсон бол хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар хурал даргалагчийг сонгоно..
- 6.8. Хувьцаа эзэмшигчдийн хуралд нэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход Компанийн тухай хуулийн 71,5, 72.1.3, 72.2, 77.1-т тус тус заасны дагуу санал хураалтыг кумулятив аргаар явуулна.
- 6.9. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 6.10. Хурлын тухай мэдээллийг нийтэд хүргэх, хуралд оролцох гишүүдийг тодруулах, санал авах ажиллагааг Компанийн тухай хууль, Компаниас баталсан журмын дагуу явуулна.

- 6.11. Хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 68 дүгээр зүйлд заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хуралд өөрийн биеэр буюу Иргэний хуулийн 63-64 дүгээр зүйлд зааснаар бичгээр олгосон хуулийн хүчин төгөлдөр итгэмжлэлийг үндэслэн өөр этгээдээр төлөөлүүлэн оролцуулж болно.
- 6.12. Хувьцаа эзэмшигч хурлаас гарах шийдвэрийн төсөлд саналын хуудсаар санал ирүүлсэн тохиолдолд түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон гэж үзнэ. Уг санал нь Компанийн тухай хуулийн холбогдох шаардлагыг хангасан байна.
- 6.13. Компанийн саналын эрхтэй хувьцааны энгийн олонх хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно. Хурлын ирцэд заасан хувь хүрээгүй бол хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэж хурлыг дахин хуралдуулах өдрийг товлож энэ тухай тэмдэглэл үйлдэж ТУЗ-ийн дарга, тэмдэглэл хөтлөгч гарын үсэг зурна. Хойшлогдсон хурлаар хэлэлцэх асуудлыг өөрчлөхгүй болно.
- 6.14. Хойшлогдсон хурлыг Компанийн тухай хуулийн 69.6-д заасан журмын дагуу ажлын 20 хоногийн дотор хуралдуулна. Өмнөх хуралд ирүүлсэн саналыг хойшлогдсон хурлын ирц, санал хураалтын дүнд тооцно.
- 6.15. Саналын эрхийн гуравны нэг ба түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцсоноор хойшлогдсон хурал хүчин төгөлдөр болно Саналын эрхийн 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах; нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах; компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох; компанийн хэлбэрийг өөрчлөх; компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох; хувьцааг хуваах буюу нэгтгэх тухай асуудлыг хэлэлцэх хойшлогдсон хурал нь саналын эрхийн гуравны нэгээс доошгүй хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор хүчин төгөлдөр болно.
- 6.16. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудлыг цахим хэлбэрээр, эчнээ санал хураах замаар шийдвэрлэж болно. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулж болохгүй. Хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах тохиолдолд энэ дүрмийн 6.3-д заасан журмын 4 дүгээр бүлэгт зааснаар зохион байгуулна.
/Энэ хэсгийг 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 03 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/
- 6.17. Цахим хэлбэрээр болон эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд энэхүү шийдвэрт компанийн тухай хуулийн 73.3-г заасан асуудлыг тусгасан байна.
/Энэ хэсгийг 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 03 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/
- 6.18. Цахим хэлбэрээр болон эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлыг тусгасан санал хураах хуудас, цахим санал хураалтыг хүлээн авах сүүлчийн өдрөөс ажлын 30-аас доошгүй хоногийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэдэг аргаар хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх бөгөөд саналын хуудсыг хүлээн авах, цахим санал хураалтыг хянах, шалгах, санал тоолох ажлыг Тооллогын комисс хариуцан гүйцэтгэнэ.
/Энэ хэсгийг 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 03 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/
- 6.19. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, тогтоолыг Компанийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан журмын дагуу хөтөлж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга баталгаажуулан гарын үсэг зурна.

Долоо. Төлөөлөн удирдах зөвлөл, түүний бүрэн эрх

- 7.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага нь Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/ байна. ТУЗ нь Компанийн тухай хууль, энэ дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад Компанийн тухай хуулийн 76 болон дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
 - 7.1.1. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;
 - 7.1.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын бүртгэлийн өдөр, хурлын товьыг тогтоох;
 - 7.1.3. ҮТЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх захирлын цалин, урамшуулын хэмжээг тогтоох;
 - 7.1.4. Компанийн тухай хууль болон хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх зэрэг болно.
- 7.2. Компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байна. ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 3 (гурав) жилийн хугацаатай сонгох ба ТУЗ-ийн гишүүний эрх дараагийн ТУЗ-ийн гишүүд сонгогдсоноор дуусгавар болно. ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгож болох бөгөөд хувьцаа эзэмшигч биш этгээд ТУЗ-ийн гишүүнээр сонгож ажиллуулж болно. ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэг нь хараат бус гишүүдээс бүрдэнэ.
/Энэ хэсгийг 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 03 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/
- 7.3. Гишүүн нь удаан хугацаагаар үүргээ биелүүлж чадахгүй болсон тохиолдолд ТУЗ-аас түүний оронд өөр хүнийг түр томилно.
- 7.4. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар сонгоно. ТУЗ-ийн даргын эзгүйд түүний томилсон, эсхүл ТУЗ-ийн томилсон гишүүн үүрэг гүйцэтгэнэ.
- 7.5. ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэл хөтлүүлэх, хяналт тавих, баталгаажуулах үүрэгтэй.
- 7.6. ТУЗ-ийн хурал хуралдуулах хугацааг ТУЗ-ийн дотоод журмаар тогтооно. Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагааныхаа журмыг тогтоож батална.
- 7.7. ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, компанийн гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад этгээдийн шаардлага, санаачилгаар хуралдуулна. ТУЗ эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.
- 7.8. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь гишүүдэд хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох материалыг ажлын 2-оос доошгүй хоногийн өмнө хүргүүлнэ.
- 7.9. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор ТУЗ-ийн хурал хүчин төгөлдөр болно. ТУЗ-ийн гишүүд асуудлыг дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 7.10. ТУЗ-ийн хэлэлцэж шийдвэрлэсэн хүчин төгөлдөр шийдвэргүйгээр ТУЗ-ийн дарга нь дангаараа эсхүл аль нэг гишүүн болон зарим гишүүд хамтран ТУЗ-ийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, бүрэн эрхэд нь хамаарах асуудлаар шийдвэр гаргах буюу төлөөлөн удирдах зөвлөлөөр сонгогдоогүй тохиолдолд ТУЗ-ийн байр суурийг төлөөлөх эрхгүй.
- 7.11. ТУЗ нь хуралдаанаар хурлын тэмдэглэл хөтлөх бөгөөд тэмдэглэлд хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурах бөгөөд бичгээр саналаа өгсөн гишүүдийн саналыг ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд хавсаргана.
- 7.12. ТУЗ-ийн шийдвэр нь тогтоолын хэлбэртэй байх бөгөөд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 7.13. Энгийн хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч нь ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.
- 7.14. ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтны хүлээх үүргийг хэрэгжүүлэхээс гадна, дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- 7.14.1 компанийн ашиг сонирхлын төлөө, үнэнч шударгаар ажиллах;
- 7.14.2 ажил үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн нууц болон нийтэд тараагдаагүй мэдээллийг өөрийн хувийн ашиг сонирхол буюу бусад этгээдийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байх;
- 7.14.3 ТУЗ-д аливаа сонирхлын зөрчлийн талаар мэдээллээ бичгээр мэдэгдэх;
- 7.14.4 өрсөлдөгч компанийн ТУЗ-ийн гишүүн, ажилтан, албан хаагчаар ажиллахгүй байх;
- 7.14.5 ТУЗ-ийн хуралд идэвхитэй оролцож, ажлын туршлага, өөрийн мэдлэг, ур чадвар, нөөц бололцоог дайчлах, хувьцаа эзэмшигчдийн хуралд ажлаа тайлагнах үүрэгтэй.
- 7.15. ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болох бөгөөд өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготойгоор 1. Аудитын хороо 2. Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо, 3. Стратеги, бизнес хөгжлийн хороог тус тус байгуулан ажиллуулна.
- 7.16. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна. Үүнд:
 - 7.16.1 Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
 - 7.16.2 Аудитын байгууллагыг сонгох, тэдний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;
 - 7.16.3 Хорооны чиг үүрэгт хамаарах асуудлаар шалгалт хийж дүгнэлт гаргах талаар хөндлөнгийн аудитын байгууллагад чиглэл өгөх (чухам ямар чиглэлээр шалгалт хийж, дүгнэлт гаргасан байх талаар аудитын байгууллагатай байгуулах гэрээнд тусгах замаар энэ эрхээ хэрэгжүүлнэ);
 - 7.16.4 Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;
 - 7.16.5 Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.
- 7.17. Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо нь дараах үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 7.17.1 ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;
 - 7.17.2 ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүдийн хувьд Компанийн тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
 - 7.17.3 ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;
 - 7.17.4 ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
 - 7.17.5 Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;
 - 7.17.6 ТУЗ-ийн гишүүдээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;
 - 7.17.7 Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байгаа эсэх, хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон мэдээллийг нийтийн хүртээл болгож байгаа байдалд хяналт тавих;
 - 7.17.8 ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

- 7.17.9 ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;
 - 7.17.10 Компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх;
 - 7.17.11 Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг
- 7.18. Стратеги, бизнес хөгжлийн хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 7.18.1 Компанийн стратеги төлөвлөгөөг судалгааны үндсэн дээр боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэлт гаргах
 - 7.18.2 Санхүүгийн тайлан, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн стратеги төлөвлөлтөд нийцсэн эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гаргах, шинээр хийгдэх их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд стратегийн эрсдэлийн урьдчилан дүгнэлт гаргах, чиглэл, зөвлөмж боловсруулах;
 - 7.18.3 Компанийн үнэ цэнийг тодорхойлж, хувьцааны үнэ цэнийг дээшлүүлэх, хамгаалахад чиглэсэн бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтэнд хяналт тавих, дүгнэлт гаргах;
 - 7.18.4 Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж стратегийн удирдамж чиглэлээр хангаж ажиллах ба дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, стратеги төлөвлөлт, хууль тогтоомжийн хэрэгжилт, томоохон гэрээ хэлцэлүүд, компанийн өөрчлөн байгуулалт (нэгтгэх, нийлүүлэх, хуваах, тусгаарлах г.м) зэрэгт хяналт тавьж ажиллана;
 - 7.18.5 Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн чиглэлээр компанийн бүтээгдэхүүн хөгжүүлэх багийг удирдан чиглүүлж, зөвлөж ажиллана,
- 7.19. ТУЗ-ийн гишүүн нь тухайн жилд гурав болон түүнээс дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ТУЗ-ийн хуралд биеэр оролцоогүй, аливаа хэлбэрээр саналаа өгөөгүй мөн компанийн холбогдох үйл ажиллагаа, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоогүй, идэвхи хариуцлагагүй үйл ажиллагаа явуулсан тохиолдолд ТУЗ-ийн хурлаар уг гишүүнд хариуцлага тооцох, цалин урамшууллыг олгохгүй байх зэргээр шийдвэрлэх эрхтэй.
- 7.20. ТУЗ нь нарийн бичгийн даргатай байх ба түүнийг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилно.
- 7.21. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Компанийн тухай хуулийн 82 дугаарт заасан үүргийг гүйцэтгэнэ.
- 7.22. Компанийн нарийн бичгийн дарга нь ХЭ-ийн хурлын болон ТУЗ-ийн хурлын үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг зохих журмын дагуу үйлдэх, боловсруулах, бүртгэл хөтлөх, холбогдох этгээдээс хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах, архивт шилжүүлэх зэрэг ажиллагааг эрхлэн гүйцэтгэнэ
- 7.23. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь компанийн бүртгэлд дараахи зүйлийг заавал тусгаж бүртгэнэ.
- 7.23.1 Хувьцаа эзэмшигч тус бүрийн овог нэр, эзэмшиж буй хувьцааны тоо, тэдгээрийн нийт үнийн дүн олгосон ногдол ашиг,
 - 7.23.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг товлосон он, сар, өдөр, газар, цаг болон хурлын дарга, нарийн бичгийн даргын овог нэр, хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн тоо, хурлаар хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэр, тогтоол тус бүрт хувьцаа эзэмшигчдийн өгсөн санал.

Найм. Гүйцэтгэх удирдлага

- 8.1 Компанийн гүйцэтгэх удирдлага (цаашид “Гүйцэтгэх захирал” гэх) нь энэ дүрэмд заасан болон ТУЗ-тай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 8.2 Гүйцэтгэх захирал өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад давхар ажиллахыг хориглоно.
- 8.3 Гүйцэтгэх удирдлагын төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.
- 8.4 Компанийн гүйцэтгэх удирдлагыг хувь хүн хэрэгжүүлэх бөгөөд уг этгээд компанийн Гүйцэтгэх захирал байна. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болох бөгөөд ТУЗ-ийн дарга байхыг хориглоно.
- 8.5 Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх, гэрээ байгуулах зэрэг Компанийн тухай хууль болон энэ дүрэмд зааснаар компанийг бүхий л харилцаанд итгэмжлэлгүйгээр төлөөлнө.
- 8.6 Гүйцэтгэх захирал нь албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-д нэг сарын өмнө бичгээр мэдэгдсэнээр ТУЗ-ийн хурлаар авч хянан хэлэлцэнэ.
- 8.7 ТУЗ Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг зогсоох, хязгаарлах эрхийг хэзээ ч хэрэгжүүлж болно.
- 8.8 Гүйцэтгэх захирлын жил бүрийн гүйцэтгэлийн үнэлгээг холбогдох хороогоор хэлэлцэж, ТУЗ-д тухай бүр тайлагнаж ажиллана.
- 8.9 Гүйцэтгэх удирдлага нь Компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахдаа Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, зохистой эрсдлийн түвшинд компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдах зохион байгуулах зарчмыг баримталж ажиллана.
- 8.10 Гүйцэтгэх удирдлага нь компанийн үйл ажиллагааг холбогдох хууль эрх зүйн орчин, энэхүү дүрэм, стратеги, бизнес төлөвлөгөө, жил бүрийн санхүү, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв болон ТУЗ-ийн шийдвэрээр түүнд олгосон эрх хэмжээний хүрээнд удирдах бөгөөд сар, улирал, жилийн тайлан, шаардлагатай бусад тайланг ТУЗ, Хувьцаа эзэмшигчид болон холбогдох байгууллагад тухай бүр хүргүүлнэ.
- 8.11 Гүйцэтгэх захирлын эдлэх эрх хэмжээг түүнтэй байгуулсан гэрээнд тодорхой тусгах бөгөөд Гүйцэтгэх захирал нь дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:
 - 8.11.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, тухайн жилийн бизнес төлөвлөгөө, ТУЗ-ийн шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах
 - 8.11.2 ТУЗ-өөс баталсан зардлын хэмжээнд багтаан компанийн ажилтнуудын орон тоо, үндсэн болон нэмэгдэл цалин хөлс, тэтгэмж, хөнгөлөлт, урамшууллын хэмжээг тогтоох
 - 8.11.3 Ажилтнуудын ажил үүргийн хуваарийг тогтоох, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх
 - 8.11.4 Өөрт олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулах
 - 8.11.5 Компанийн үйл ажиллагааг зохион байгуулан явуулж өдөр тутмын мэргэжлийн удирдлагаар хангах
 - 8.11.6 Компанийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах

- 8.11.7 Компанийн албадыг нэгдсэн удирдлагаар хангах, компанийн бүтэц зохион байгуулалтын нэгжийг байгуулан ажиллуулах, гүйцэтгэх удирдлагыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх удирдлагын багийн гишүүдийг томилох, чөлөөлөх, /Энэ хэсгийг 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 03 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/
- 8.11.8 Компанид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хөндөгдсөн эрхийг сэргээлгэх асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах, компанид холбогдох иргэний хэрэгт нэхэмжлэгч хариуцагчаар оролцох
- 8.11.9 Компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан бусад эрх.
- 8.12 Гүйцэтгэх захирал нь өөрийн эрх, үүргийг итгэмжлэлийн үндсэн дээр 21 хоногоос дээшгүй хугацаагаар холбогдох албан тушаалтанд шилжүүлж болно. Ийнхүү эрхээ шилжүүлсэн нь хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй
- 8.13 Гүйцэтгэх захирал болон шаардлагатай тохиолдолд удирдлагын багийн гишүүд нь ажлаа ТУЗ-д тайлагнана.

Ес. Компанийн эрх бүхий албан тушаалтан, түүний хүлээх хариуцлага

- 9.1 ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал, Үйл ажиллагаа хариуцсан захирал, Санхүү хариуцсан захирал, Ерөнхий нягтлан бодогч, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэр гаргахад оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.
/Энэ хэсгийг 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 03 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/
- 9.2 Эрх бүхий албан тушаалтан нь “Компанийн тухай хууль”, энэхүү дүрэм, ТУЗ-өөс баталсан дотоод журамд заасан үүргийг биелүүлж, компанийн эрх ашгийн төлөө үнэнч шударгаар ажиллах үүрэгтэй.
- 9.3 Эрх бүхий албан тушаалтан нь дараахь хууль бус үйл ажиллагаа явуулсаны улмаас компани, хувьцаа эзэмшигч болон зээлдүүлэгчид учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцна.
- 9.3.1. Компанийн нэрийг хувийн сонирхлоор ашигласан;
- 9.3.2. Хувьцаа эзэмшигч болон зээлдүүлэгчид санаатайгаар хуурамч мэдээлэл өгсөн; мэдээлэл өгөх үүргээ биелүүлээгүй;
- 9.3.3. Компанийн бичиг баримтыг энэ дүрэм болон бусад дүрэм, журамд заасны дагуу хадгалаагүй, зөвшөөрөлгүйгээр гадны этгээдэд дамжуулсан, нууцын зэрэглэлийг алдагдуулсан зэрэг зөрчил гаргасан;
- 9.3.4. Компанийн дүрэм, ТУЗ-өөс баталсан дотоод журмыг ноцтой зөрчсөн, компанийн нууц мэдээг гуравдагч этгээдэд дамжуулсан, эсхүл хувийн зорилгоор ашигласан;
- 9.3.5. ТУЗ болон компанитай байгуулсан хөдөлмөрийн болон бусад гэрээ, компанийн дүрмээр тогтоосон эд хөрөнгө захиран зарцуулах эрх хэмжээг хэтрүүлсэн;
- 9.3.6. “Компанийн тухай хууль”-ийн 98 дугаар зүйлд заасан мэдээллийг мэдээлэл авах эрх бүхий этгээдэд гаргаж өгөөгүй, хугацаа хожимдуулан гаргаж өгсөн;

Арав. Компанийн аудиторын хяналт

- 10.1. Монгол улсын Аудитийн тухай хуульд заасны дагуу компанийн санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон

- хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь эрх бүхий байгууллагаас зөвшөөрөгдсөн аудитын байгууллагатай гэрээ байгуулан ажиллана.
- 10.2. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь аудитын байгууллагыг сонгож түүнтэй байгуулах гэрээг батлах бөгөөд гэрээнд аудитын байгууллагын эрх, үүрэг, хариуцлага, аудитын үйлчилгээнд төлөх хөлсний хэмжээг заана.
 - 10.3. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудиторовн шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна. Компанийн жилийн санхүүгийн тайланг баталгаажуулахын тулд ээлжит шалгалт хийнэ.
 - 10.4. Ээлжит бус шалгалтыг ТУЗ, түүний аудитын хороо, эсвэл энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигчийн шаардсанаар болон гүйцэтгэх захирлын шийдвэрээр хэдийд ч хийж болно. Хувьцаа эзэмшигчийн захиалгаар хийгдсэн шалгалтын хөлсийг тухайн хувьцаа эзэмшигч хариуцаж төлөх бөгөөд шалгалтын явцад эрх бүхий албан тушаалтан эсхүл хувьцаа эзэмшигч компани, хувьцаа эзэмшигч болон зээлдүүлэгчид хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.
 - 10.5. Компанийн эрх бүхий албан тушаалтан аудиторовн шаардлагаар компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны талаарх баримтыг танилцуулах үүрэгтэй. Энэхүү үүргээ биелүүлээгүй албан тушаалтны буруугаас аудиторовн ажил зогссон хоногт оногдох ажлын хөлсийг буруутай этгээдээр төлүүлэх шийдвэрийг ТУЗ гаргана.
 - 10.6. Компанийн аудитор нь компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнг үндэслэн “Компанийн тухай хууль”-ийн 94.16-д заасан мэдээллийг агуулсан дүгнэлт гаргана.

**Арван нэг. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа,
бүртгэл тайлан, ногдол ашиг хуваарилах**

- 11.1. Компани санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу гаргаж баталгаажуулах бөгөөд тайланг хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна.
- 11.2. Компанийн санхүүгийн жил нь жил бүрийн 01 сарын 01-нээс 12 сарын 31-нд дуусгавар болно.
- 11.3. Компанийн санхүүгийн тайлан, түүний үнэн зөвийг компанийн гүйцэтгэх удирдлага хариуцна.
- 11.4. Санхүүгийн тайлан нь Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.1-дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.
- 11.5. Ногдол ашиг хуваарилалтын шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргана. Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолд хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах “бүртгэлийн өдөр” болон ногдол ашиг төлж эхлэх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчид мэдэгдэнэ.
- 11.6. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ашиг хуваарилна. Ногдол ашгийг бэлэн мөнгө, эд хөрөнгө, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасаар төлж болно.

**Арван хоёр. Компанийн санхүү, эдийн засгийн
үйл ажиллагаанд хяналт тавих**

- 12.1. Компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, компанийн удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн хяналтыг ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

- 12.2. Компани нь жил бүр санхүүгийн үйл ажиллагаандаа хөндлөнгийн шалгалт хийлгэж, тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагаар заавал аудит хийж гүйцэтгүүлэх бөгөөд тайланг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ.
- 12.3. Компанийн санхүүгийн тайлан үзүүлэлтүүд нь олон улсын жишгийг үндэслэн Санхүүгийн Зохицуулах Хорооноос тогтоосон нягтлан бодох бүртгэлийн зарчимд нийцсэн байна. Компани нь санхүүгийн тайлангаа улирал, жилээр гаргаж Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлнэ.
- 12.4. ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар аудитын хороо нь 3-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаатай сонгогдоно.
- 12.5. Аудитын хорооны бүрэн эрх, чиг үүрэг, гишүүдэд тавих шаардлага зэргийг журмаар зохицуулна.
- 12.6. Аудитын хороо нь хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлбар өгөх үүрэгтэй оролцох эрхтэй.
- 12.7. Аудитын хороо нь ТУЗ-д ажлаа тайлагнана.
- 12.8. Аудитын хороо нь аудитын тухай хуульд заасны дагуу компанийн санхүүгийн тайланг баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг ТУЗ-өөр батлуулна.
- 12.9. Гэрээнд компанийн болон аудитын байгууллагын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээг заана.
- 12.10. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих аудитын байгууллагын шалгалт нь ээлжит болон ээлжит бус байна.
- 12.11. Компанийн жилийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд ээлжит шалгалт хийнэ.
- 12.12. Дараах этгээдийг компанийн дотоод аудитор болон аудитын байгууллагаар сонгон ажиллуулахыг хориглоно. Үүнд:
 - 12.12.1 компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээрт нэгдмэл сонирхолтой этгээд компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилтан, эрх бүхий албан тушаалтан бол;
 - 12.12.2 компани болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, эсхүл компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эзэмшдэг бол;
 - 12.12.3 компанитай аудитаас бусад асуудлаар аливаа хэлцэл хийсэн этгээд бол;
- 12.13. Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1-д заасан компанийн бичиг баримтыг Компани нь хяналт шалгалт, лавлагаа, түүх, архивын зорилгоор холбогдох хуульд зааснаар хадгална.

Арван гурав. Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах

- 13.1 Компанийг ХЭХ-ын шийдвэрээр буюу Компанийн хуульд заасан бусад үндэслэлээр өөрчлөн байгуулах (нэгтгэх, нийлүүлэх, хуваах, тусгаарлах, өөрчлөн зохион байгуулах) замаар өөрчлөн байгуулж болно.
- 13.2 Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг Компанийн тухай хуулийн 18-24 дүгээр зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.
- 13.3 ХЭХ-ын шийдвэрээр компанийг татан буулгах ажиллагааг ТУЗ-өөс томилогдсон Татан буулгах комисс, хэрэв шүүхийн шийдвэрээр татан буугдаж байгаа бол шүүхээс томилсон хэрэг гүйцэтгэгч гүйцэтгэнэ.
- 13.4 Дор дурьдсан үндэслэлээр шүүх компанийг татан буулгана
 - 13.4.1. Компани дампуурсан;

- 13.4.2. Нэг ч гишүүн үлдээгүй;
- 13.4.3. Хуульд заасан бусад үндэслэл;
- 13.5. Компанийг татан буулгах тохиолдолд нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг хангасны дараа үлдсэн хөрөнгө (үүний дотор компанийн эд хөрөнгийг борлуулсны орлого мөн орно)-ийг Компанийн хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд хуваарилна.
- 13.6. Компанийг бүртгэх байгууллага улсын бүртгэлээс хассанаар татан буулгасанд тооцно.

Арван дөрөв. Бусад нөхцөлүүд

- 14.1 Энэхүү дүрэмд гагцхүү хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 14.2 Энэхүү дүрэм болон холбогдох журамд шууд заагаагүй аливаа суудлыг тухайн үед нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын хууль болон эрх зүйн бусад актаар зохицуулна.
- 14.3 Энэхүү дүрэм нь УБЕГ-ын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар бүртгүүлснээр хүчин төгөлдөр болж Компани татан буугдах буюу өөрчлөн байгуулагдах хүртэл хугацаагүй үйлчилнэ.
- 14.4 Энэхүү дүрэм нь Монгол хэл дээр 2 хувь үйлдэж, УБЕГ-ын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар компанид тус тус нэг нэг хувийг хадгална.

